

СУДАЛГААГ ДЭМЖИХ ЖИЛИЙН САНХҮҮЖИЛТИЙН ТҮР ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. МУИС 2014-2015 оны хичээлийн жилийг судалгааг дэмжих жил болгосонтой холбогдуулан судлаач багш нарыг дэмжих, эрдэм шинжилгээний бүтээл, мэргэжлийн сэтгүүлийн чанарыг сайжруулах үйл ажиллагааг санхүүжүүлэх харилцааг зохицуулахад энэхүү түр журмын (цаашид түр журам гэх) зорилго оршино.

1.2. Судалгааны санхүүжилтийг профессор багш нарт суурь болон хувьсах зардал хэлбэрээр олгох, салбар хоорондын цогц судалгаа хийх залуу судлаачдын багт грант олгох, өндөр түвшний судалгааны үр дүнг нийгэм, эдийн засгийн эргэлтэнд оруулах, МУИС-ийн судалгааны чиглэлтэй холбоотой эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийг дэмжихэд зарцуулна.

1.3. Бүх хэлбэрийн төслийг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлж, санхүүжүүлнэ.

Хоёр. Профессор, дэд профессор нарт судалгааны зардал олгох

2.1. МУИС-д профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж байгаа үндсэн орон тооны багш нарт судалгааны суурь болон хувьсах зардал олгоно.

2.1.1. Профессорын зэрэглэлд ажиллаж буй багшид 2 сая (хоёр сая) төгрөгийн, дэд профессорын зэрэглэлд ажиллаж буй багшид 1 сая (нэг сая) төгрөгийн судалгааны суурь зардал олгоно.

2.1.2. Судалгааны туслах, гэрээт эрдэм шинжилгээний ажилтнаар ажиллуулж, сургалтын тэтгэлэг олгож буй магистрант, докторант оюутны тооноос хамааруулан профессор, дэд профессор багш нарт хувьсах зардлыг нэмж олгоно.

2.2. Дээрх санхүүжилтийг судалгааны дараах төрлийн зардалд зарцуулна.
Үүнд:

- Олон улсын мэргэжлийн сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх;
- Судалгааны тоног төхөөрөмж, материал, мэргэжлийн ном, сэтгүүл өгүүлэл, программ хангамж худалдан авах;
- Оюутанд ажлын хөлс, тэтгэлэг олгох;

- Олон улсын хуралд оролцох, семинар, симпозиум зохион байгуулах. (суурь зардлыг цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглоно.)

2.3. Профессор, дэд профессорын зэрэглэлд ажиллаж буй багш нар судалгааны зардал авах төслийн саналаа хавсаргасан загвар (Хүснэгт 1) ашиглан бичиж, зохих баримтуудыг хавсарган тэнхимийн эрхлэгчээрээ дамжуулан 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор бүрэлдэхүүн сургууль, салбарын захиргаанд ирүүлнэ.

2.4. Бүрэлдэхүүн сургууль, салбарын захиргааны зөвлөл 2014 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн дотор хувьсах зардлын хэмжээг тогтооно.

Гурав. Залуу судлаачдын багт грант олгох

3.1. Докторын зэрэгтэй 40 хүртэлх насны, 3-аас цөөнгүй залуу судлаачдаас бүрдсэн багт салбар дундын судалгааны грант олгоно.

3.1.1. Залуу судлаачдын салбар дундын судалгааны нэг багт олгох грант нь 10 сая (арван сая) хүртэл төгрөг байна.

3.1.2. Грантын зардлыг судалгааны зардлаас гадна 2.2 дугаар зүйлд заасан хэлбэрээр зарцуулна. (цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглоно.)

3.2. Грантыг судалгааны салбар дундын чанар, судалгааны нээлттэй, дундын ашиглалттай дэд бүтцийг бүрдүүлэх боломж, судалгааны ажлын үр дүнгээр олон улсын сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, оюуны өмч бий болгох боломж, хамтарсан судалгаа, семинараар дамжуулан янз бүрийн салбарын залуу эрдэмтэд, оюутнуудын хоорондын хамтын ажиллагаа гүнзгийрч, цаашид цогц судалгааг тогтмол хийх соёл төлөвших, баг бүрдэх байдал зэргийг харгалзан олгоно.

3.3. Залуу судлаачдын баг төслийн санал дэвшүүлэх бөгөөд хүлээгдэж буй үр дүнгээ 1 жилийн хугацаагаар тооцож тодорхой тусгах шаардлагатай.

3.4. Залуу судлаачдын багт грант олгох төслийн саналыг 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор хавсаргасан загвар (Хүснэгт 2) ашиглан бичиж, Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтэс (ЭШИХ)-т цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээн авч, сонгон шалгаруулалтыг 2014 оны 12 дугаар сарын 25-ны дотор зохион байгуулна.

3.5. Сонгон шалгаруулах хороо нь эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал, бүрэлдэхүүн сургууль, салбарын захирлын бүрэлдэхүүнтэй байна.

3.6. Санхүүжилтийн гэрээг Эрдэм шинжилгээ инновацийн асуудал эрхэлсэн дэд захиралтай хийнэ.

Дөрөв. Мэргэжлийн сэтгүүлийг дэмжих грант/санхүүжилт олгох

4.1. МУИС-иас эрхлэн гаргадаг болон мэргэжлийн холбоодтой хамтран хэвлүүлдэг олон улсын ISSN дугаартай сэтгүүлийг хэвлэн нийтлүүлэхэд 500.000 (таван зуун мянга) төгрөгийн суурь санхүүжилт олгоно. Сэтгүүлд үнэлгээ хийж, үнэлгээний дүнд харгалзуулан нэмэлт санхүүжилт олгож болно.

4.2. Мэргэжлийн нэг сэтгүүлд ноогдох нэмэлт санхүүжилт нь 4.4-д заагдсан шалгуур үзүүлэлтээс хамааран 2.5 сая (хоёр сая таван зуун мянга) хүртэл төгрөг байна.

4.3. Сэтгүүлд олгосон санхүүжилтийг дараах хэлбэрээр зарцуулна. Үүнд:

- Редакцийн зөвлөл, өгүүлэл хянагч гишүүн, хөндлөнгийн шинжээчийн урамшуулал;
- Ном зүйн мэдээллийн сан үүсгэх, онлайн менежментийн зардал (онлайн хэлбэрээр хэвлэх, онлайнгаар өгүүлэл хүлээн авах г.м.);
- Хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх зардал.

4.4. Энэ журмын 3.5-т заасан үнэлгээний хороо сэтгүүлийн үнэлгээг хийхдээ доорхи гол шалгуур үзүүлэлтийг харгалзана. Үүнд:

4.4.1. Сэтгүүлийн тогтвортой хэвлэгдсэн байдал (сүүлийн 3-аас доошгүй жил тогтмол хэвлэгдсэн байх);

4.4.2. Сэтгүүлийн редакцийн зөвлөл, өгүүллийн хянагч нь тухайн шинжлэх ухааны чиглэлээр хүлээн зөвшөөрөгдсөн, нэр хүндтэй гадаад, дотоодын эрдэмтэд байх;

4.4.3. Сэтгүүлийн хөндлөнгийн хянан магадлагааны (peer-review) тогтолцоо нь төлөвшсөн байх, редакцийн зөвлөлийн гишүүдийн 30-аас дээш хувь нь олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн бүтээл бүхий гадаадын эрдэмтэд байх;

4.4.4. Англи хэлээр хэвлэгддэг, эсвэл англи хураангуй бүхий монгол хэлээр хэвлэгддэг, мөн англи, монгол хэлээр дугаар нь ээлжлэн гардаг байх;

4.4.5. Сэтгүүл нь тухайн шинжлэх ухааны чиглэлийн олон улсын мэргэжлийн сэтгүүлийн мөрддөг нийтлэг шинжлэх ухааны бичлэг, эшлэл хийх загвар, стандартыг мөрддөг байх.

4.4.6. Энэхүү санхүүжилтээр шинэ сэтгүүл бий болгох, хэвлэх үйл ажиллагааг дэмжихгүй.

4.5. Сэтгүүлийн редакцийн зөвлөлийн дарга нь тухайн сэтгүүл нь энэ журмын 4.4-д заасан шаардлагуудыг хэрхэн хангаж байгаа болон цаашид авах арга хэмжээний талаархи төслийн саналаа хавсаргасан загвар (Хүснэгт 3) ашиглан бичиж, 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор ЭШИХ-т цахим болон хэвлэмэл байдлаар ирүүлнэ.

4.6. Эрдэм шинжилгээ, инновацийн асуудал эрхэлсэн дэд захирал, бүрэлдхүүн сургууль, салбарын захирлын бүрэлдэхүүнтэй үнэлгээний комисс 2014 оны 12 дугаар сарын 31-ний дотор сэтгүүл тус бүрд олгох хувьсах зардлын хэмжээг тогтооно.

Тав. Өндөр түвшний судалгааны төслийн санхүүжилт олгох

5.1. Судалгааны ажлын үр дүнг олон улсын мэргэжлийн сэтгүүлд хэвлүүлэх, оюуны өмчийн хамгаалалт хийх, түүнийгээ үйлдвэрлэлд нэвтрүүлэх зорилго бүхий профессор багш, судлаачдын дэвшүүлсэн ахисан түвшний төслийг сонгон шалгаруулж санхүүжүүлнэ. Нэг төсөлд олгох санхүүжилтийн хэмжээ нь 10 сая (арван сая) хүртэл төгрөг байна. Төсөл нь доорхи шаардлагыг хангасан байна.

- 5.1.1. Импакт фактор бүхий олон улсын сэтгүүлд нэгдүгээр болон холбоо барих зохиогчоор нэгээс доошгүй, хамтран зохиогчоор хоёроос доошгүй өгүүлэл хэвлүүлэх (хэвлэхээр зөвшөөрөгдсөн (accepted) өгүүллийг үр дүнд тооцож болно);
- 5.1.2. МУИС-ийн нэр дээр оюуны өмч мэдүүлэх, эрхийн хамгаалалт хийлгэх;
- 5.1.3. МУИС-ийн нэр дээр авсан оюуны өмчөө үйлдвэрлэлд нэвтрүүлэх, гарааны компани байгуулах нөхцлийг бүрдүүлэх;
- 5.1.4. Ахисан түвшний төслийн зардлыг судалгааны зардлаас гадна 2.2 дугаар зүйлд заасан хэлбэрээр зарцуулна. (цалин, ажлын хөлсөнд зарцуулахыг хориглоно).

5.2. Профессор багш, судлаачид ахисан түвшний судалгааны төслийн санал дэвшүүлэх бөгөөд хүлээгдэж буй үр дүнгээ 1 жилийн хугацаагаар тооцож тодорхой тусгах шаардлагатай.

5.3. Ахисан түвшний төслийн саналыг хавсаргасан загвар (Хүснэгт 4) ашиглан бичиж, 2014 оны 12 дугаар сарын 15-ны дотор ЭШИХ-т цахим болон хэвлэмэл хэлбэрээр хүлээн авч, сонгон шалгаруулалтыг мөн оны 12 дугаар сарын 25-ны дотор зохион байгуулна. Сонгон шалгаруулах хороо нь энэ журмын 3.5-т заасан бүрэлдэхүүнтэй байна.

5.4. Санхүүжилтийн гэрээг Эрдэм шинжилгээ инновацийн асуудал эрхэлсэн дэд захиралтай хийнэ.

Зургаа. Тайлан, үр дүнгийн баталгаажуулалт

6.1. Судалгааны суурь ба хувьсах зардал авсан профессор, дэд профессор багш нар эрдэм шинжилгээний болон санхүүгийн тайлангаа 2015 оны 12 дугаар сарын 15-ны дотор бүрэлдэхүүн сургууль/салбарын Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн үнэлүүлж, ЭШИХ-т ирүүлнэ.

6.2. Грант болон өндөр түвшний судалгааны ажлын явцын тайланг (хагас жилээр) 2015 оны 06 дугаар сарын 15-ны дотор хэвлэмэл болон электрон хэлбэрээр ЭШИХ-т ирүүлнэ. Төслийн эцсийн тайлан нь санхүүгийн тайлан, судалгааны үр дүнгийн баталгаажуулалтаас бүрдэх ба бүрэлдэхүүн сургууль/салбарын Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн үнэлүүлж, 2015 оны 12

дугаар сарын 15-ны дотор багтаан хэвлэмэл болон электрон хэлбэрээр ЭШИХ-т ирүүлнэ.

6.3. Эрдэм шинжилгээний сэтгүүлийг дэмжих төслийн тайланг сэтгүүлийн ерөнхий редактор бүрэлдэхүүн сургууль/салбарын Эрдмийн зөвлөлөөр хэлэлцүүлэн үнэлүүлж, 2015 оны 12 дугаар сарын 15-нд багтаан ЭШИХ-т ирүүлнэ.

6.4. МУИС нь импакт фактор (IF) бүхий олон улсын сэтгүүлд хэвлүүлсэн өгүүллийг илүүд үзнэ.

6.5. Хурлын илтгэлийн хураангуйг залуу судлаачдын грант болон ахисан түвшний судалгааны ажлын үр дүнд тооцохгүй.

6.6. Төслийн гүйцэтгэлийн явц санхүүжүүлэгчээс үл хамаарах шалтгаанаар удаашрах, үр дүн нь гэрээнд заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд ЭШИХ-ийн зүгээс хугацаанаас нь өмнө гэрээг цуцлах, санхүүжүүлсэн хөрөнгийг гүйцэтгэгчээр нөхөн төлүүлэх талаар Захиргаа, хяналт, шинжилгээний албанд санал тавьж шийдвэрлүүлнэ.

Долоо. Төслийн үр дүнг түгээх

7.1. Грант, ахисан түвшний судалгааны үр дүнгийн тайлан, сэтгүүлийн мэдээллийг Эрдэм шинжилгээ, инновацийн хэлтсийн мэдээллийн санд оруулна.

7.2. Гүйцэтгэгч төслийн үр дүнг хэвлэн нийтлүүлэх, эрдэм шинжилгээний хуралд илтгэх, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, интернетээр мэдээлж түгээх, сурталчлахдаа МУИС-ийн санхүүжилтээр хэрэгжүүлсэн төслийн хүрээнд гүйцэтгэсэн болохыг заавал дурьдана.

ПРОФЕССОР, ДЭД ПРОФЕССОРЫН

СУДАЛГААНЫ ЗАРДЛЫН КАРТ

2014 оны 11 сарын байдлаар

1	Профессор/ Дэд профессорын нэр, эрдмийн зэрэг цол, харъяалал			
2	Судалгааны туслах, гэрээт Эрдэм, шинжилгээний ажилтнаар ажиллуулж буй магистрант, докторантын нэр, олгосон цалин, тэтгэлэг хүн тус бүрээр - <i>Тушаал, шийдвэрийг баримтаар хавсаргах</i> - <i>Олгож буй ажлын хөлс, тэтгэлгийн хэмжээг баримтаар хавсаргах</i>	Нэрс	Тушаал, шийдвэр	Цалин, тэтгэлэг
3	Судалгааны чиглэл			
4	Судалгааны суурь зардлын зарцуулалтын санал (<i>тодорхой бичиж, хавсаргах</i>)			
5	Хүлээгдэх үр дүн			

Профессор, дэд профессорын гарын үсэг:

Холбогдох утас/имэйл хаяг:

ЗАЛУУ СУДЛААЧИЙН ГРАНТЫН КАРТ

1	Судалгааны төслийн сэдэв	
2	Удирдагчийн нэр, эрдмийн зэрэг цол, харъяалал	
3	Гүйцэтгэгчдийн нэрс, эрдмийн зэрэг цол, харъяалал	
4	Судалгааны төсөл нь түр журамд дурдсан шаардлагыг хэрхэн хангаж байгаа талаар тодорхой бичиж хавсаргах	
5	Нийт судалгааны зардлын зарцуулалтын төлөвлөгөө	
6	Ажлын календарьчилсан төлөвлөгөө	
7	Судалгааны ажлын хүлээгдэх үр дүн <i>(Олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд хэвлүүлэх өгүүлэл, авах патент гэх мэт тодорхой бичих)</i>	

Удирдагчийн гарын үсэг:

Холбогдох утас/имэйл хаяг:

МЭРГЭЖЛИЙН СЭТГҮҮЛИЙН ЗАРДЛЫН КАРТ

1	Сэтгүүлийн нэр, ISSN дугаар	
2	Редакцийн зөвлөлийн даргын нэр, эрдмийн зэрэг цол, харъяалал	
3	Редакцийн зөвлөлийн монгол гишүүдийн нэрс, эрдмийн зэрэг цол, харъяалал	
4	Редакцийн зөвлөлийн гадаад гишүүдийн нэрс, эрдмийн зэрэг цол, харъяалал	
5	Сэтгүүлийг эрхлэн гаргаж ирсэн байдал <i>(Тур журмын үзүүлэлтүүдийг хэрхэн хангасан талаар дэлгэрэнгүй бичиж, хавсаргах)</i>	
6	Сэтгүүлийг цаашид хөгжүүлэх үндэслэл, шаардлага, ач холбогдол	
7	Хүлээгдэх үр дүн	
8	Төсвийг зарцуулах тооцоо	
10	Ажлын календарьчилсан төлөвлөгөө	

Редакцийн зөвлөлийн даргын үсэг:

Холбогдох утас/имэйл хаяг:

ӨНДӨР ТҮВШНИЙ СУДАЛГААНЫ ТӨСЛИЙН САНАЛЫН КАРТ

1	Төслийн сэдэв	
2	Төслийн нийт төсөв	
3	Төслийн удирдагчийн нэр, эрдмийн зэрэг цол, харъяалал	
4	Төслийн гүйцэтгэгчдийн нэрс, эрдмийн зэрэг цол, харъяалал <i>(Сүүлийн 5 жилд олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд хэвлүүлсэн, мэдүүлсэн болон эрхийн хамгаалалт хийгдсэн оюуны өмч зэрэг бүтээлийн жагсаалтыг хаасаргах)</i>	
5	Энэ төслийг хэрэгжүүлэх үндэслэл, шаардлага, ач холбогдол	
6	Төслийн хүлээгдэх үр дүн, үр дүнгийн баталгаа <i>(Олон улсын импакт фактор бүхий сэтгүүлд өгүүлэл хэвлүүлэх, МУИС-ийн нэр дээр оюуны өмч мэдүүлэх эсэх талаар тодорхой бичих)</i>	
7	Төслийн зардлын зарцуулалтын төлөвлөгөө	
8	Ажлын календарьчилсан төлөвлөгөө <i>(сараар)</i>	
Үр дүнгийн нөлөө, үр ашиг		
9	Төслийн үр дүнгийн эдийн засаг/ эдийн засгийн бус үр ашиг	
10	Төслийн хэрэгжилтэд саад болж болзошгүй эрсдэл, хүчин зүйл	

Төслийн удирдагчийн гарын үсэг:

Холбогдох утас/имэйл хаяг: